## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН МӨРДӨЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГАА БАГА ЗАРДЛААР ӨНДӨР ҮР ДҮНГ ХАНГАХАД ЧИГЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

**АУДИТЫН СЭДЭВ:** “ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

**АУДИТЫН КОД:** НТАГ-2025/21-11-ШТА-НА


Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал
Утас: 70007734 Цахим хаяг: Erdenejargalm@audit.gov.mn

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга Ч.Болд
Утас: 260512. Цахим хаяг: Boldch@audit.gov.mn

Эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга Б.Золбаяр
Утас: 315875. Цахим хаяг: Zolbayarb@audit.gov.mn

Эрсдэлийн удирдлагын хэлтсийн ахлах аудитор Э.Отгон
Утас: 315875. Цахим хаяг: Otgone@audit.gov.mn

Эрсдэлийн удирдлагын хэлтсийн аудитор А.Сэлэнгэ
Утас: 315875. Цахим хаяг: Selengea@audit.gov.mn

Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтсийн аудитор М.Одгэрэл
Утас: 327787. Цахим хаяг: Odgerelm@audit.gov.mn

Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор Э.Ундармаа
Утас: 325093. Цахим хаяг: Undarmaae@audit.gov.mn

Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор Т.Гандолгор
Утас: 325093. Цахим хаяг: Gandolgort@audit.gov.mn

Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор М.Өлзийхишиг
Утас: 325093. Цахим хаяг: Ulziikhishigm@audit.gov.mn



**Улаанбаатар хот**
**2025 он**

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**
**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН**
**ТУШААЛ**

2025 оны 05 сарын 12 өдөр Дугаар А/17 Улаанбаатар хот

**Нийцлийн аудитын тайланг баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 2.4 дэх заалт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын (НТАГ-2025/21-11-ШТА-НА) тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Х.Нямбаатар)-д зөвлөсүгэй.

3.Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлт, үр дүнг 2026 оны IV дүгээр улиралд танилцуулахыг Эрсдэлийн удирдлагын хэлтэс (Б.Золбаяр)-т үүрэг болгосугай.

4.Тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсүгэй.

М.ЭРДЭНЭЖАРГАЛ

1425010019

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Tushaal\№22--2025 05 12 NA Tailan batalgaajuulah tuhai.docx

## Агуулга


| | |
|---|---|
| **Товчилсон үгийн тайлбар** | 1 |
| **Хүснэгтийн товьёг** | 2 |
| **Дүрслэлийн товьёг** | 2 |
| **Графикийн товьёг** | 2 |
| **Хавсралтын товьёг** | 2 |
| **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл** | 3 |
| **Ерөнхий мэдээлэл** | 4 |
| **А. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН УУ?** | 5 |
| *1. Хуулийн 5-12 дугаар зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан уу?* | 5-9 |
| *2. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хэмнэлтийн бусад арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулсан уу?* | 9-12 |
| **Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬД ЗААСАН ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН УУ?** | 13 |
| *1. Хуулийн 13 дугаар зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан уу?* | 13-19 |
| *2. Цахим худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулж ажилласан уу?* | 19-20 |
| **В. ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БУСАД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ҮР ДҮНТЭЙ БАЙСАН УУ?** | 21 |
| *1. Хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд хяналтаа бүрэн хэрэгжүүлсэн үү?* | 21-23 |
| *2. Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлсэнээр хэмнэлттэй, үр ашигтай байсан уу?* | 23-24 |
| *3. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажилласан уу?* | 24 |
| **Нийслэлийн харьяа байгууллагуудаас авсан санал, асуулгын дүн** | 25-26 |
| **Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал** | 27 |
| **Нийслэл дэх Төрийн аудитын газрын тайлбар** | 28 |
| **Дүгнэлт** | 29 |
| **Зөвлөмж** | 30 |
| **Хавсралт** | 31-44 |

## Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| БХД | Багахангай дүүрэг |
| БГД | Баянгол дүүрэг |
| БЗД | Баянзүрх дүүрэг |
| ГНАХ | Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтэс |
| ДАА | Дотоод аудитын алба |
| ДХЭЗТБХГ | Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газар |
| ЗД | Засаг дарга |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| НТАГ | Нийслэл дэх Төрийн аудитын газар |
| НАОБТГ | Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар |
| НХХААГ | Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газар |
| ННҮГ | Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар |
| НД | Налайх дүүрэг |
| НОСК | Нийслэлийн орон сууцны корпораци |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОСБГ | Орон сууцны бодлогын газар |
| ОСНААУГ | Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар |
| СНАХ | Санхүү, нийцлийн аудитын хэлтэс |
| СБД | Сүхбаатар дүүрэг |
| СХД | Сонгино-Хайрхан дүүрэг |
| ТАХ | Төсөл, арга хэмжээ |
| ТХТХ | Төрийн хэмнэлтийн тухай хууль |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТБОНӨХЭ | Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ТҮТ | Тохижилт үйлчилгээний төв |
| УИХ | Улсын Их Хурал |
| УБХХОМ | Улаанбаатар хотын хөрөнгө оруулалт, менежмент |
| УСУГ | Ус сувгийн удирдах газар |
| УБХШУЗТ | Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв |
| ХАА | Худалдан авах ажиллагаа |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХК | Хувьцаат компани |
| ХУД | Хан-Уул дүүрэг |
| ХИХУГ | Хэсэгчилсэн инженер, хангамжийн удирдах газар |
| ХШҮГ | Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар |
| ХУБТ | Хүүхдийн урлан бүтээх төв |
| ЧД | Чингэлтэй дүүрэг |
| ШДТХ | Шилэн дансны тухай хууль |
| ЭЭАҮП | Эмээлт эко аж үйлдвэрийн парк |

## Хүснэгтийн товьёг


| № | Гарчиг | Хуудасны дугаар |
|---|---|---|
| Хүснэгт 1 | Нийслэлийн 2023-2024 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл | 4 |
| Хүснэгт 2 | Нийслэлийн 2023-2024 оны зөрчлийн мэдээлэл | 4 |
| Хүснэгт 3 | ТХТХ-ийн 5-12 дугаар зүйлийн зөрчлийн мэдээлэл | 5 |
| Хүснэгт 4 | Нийслэлийн харьяа байгууллагуудын ТХТХ-ийн 6 дугаар зүйлийн зөрчлийн мэдээлэл | 6 |
| Хүснэгт 5 | Нийслэлийн харьяа байгууллагуудын ТХТХ-ийн 12 дугаар зүйлийн зөрчлийн мэдээлэл | 8 |
| Хүснэгт 6 | Нийслэлийн харьяа байгууллагуудын ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын зөрчлийн мэдээлэл | 10 |
| Хүснэгт 7 | Нийслэлийн харьяа байгууллагуудын ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтын зөрчлийн мэдээлэл | 11 |
| Хүснэгт 8 | Монгол Улсын 2023, 2024 оны төсвийн тухай хууль /Нийслэлийн ЗД-д эрх шилжсэн/ болон нийслэл, дүүргийн ИТХ-ын тогтоолоор баталсан ТАХ-ний хураангуй мэдээлэл | 13 |
| Хүснэгт 9 | Улс, орон нутгийн 2023, 2024 оны ХАА-ны мэдээлэл | 14 |
| Хүснэгт 10 | ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтын зөрчлийн мэдээлэл | 15 |
| Хүснэгт 11 | ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заалтын зөрчлийн мэдээлэл | 16 |
| Хүснэгт 12 | ТХТХ-ийн 14 дүгээр зүйлийн зөрчлийн хураангуй мэдээлэл | 19 |
| Хүснэгт 13 | Нийслэлийн харьяа байгууллагуудын ТХТХ-ийн 14 дүгээр зүйлийн зөрчлийн мэдээлэл | 19 |
| Хүснэгт 14 | ТХТХ-ийн хэрэгжилттэй холбоотой ХШҮ-ний мэдээлэл | 21 |
| Хүснэгт 15 | Нийслэлийн 2023-2024 оны зөрчлийн мэдээлэл | 22 |
| Хүснэгт 16 | Нийслэлийн 2023-2024 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл | 23 |
| Хүснэгт 17 | ТХТХ-ийн 20.5 дахь заалтын зөрчлийн мэдээлэл | 24 |
| Хүснэгт 18 | Санал асуулга, хариултын нэгтгэл | 25-26 |


## Дүрслэлийн товьёг


| № | Гарчиг | Хуудасны дугаар |
|---|---|---|
| Дүрслэл 1 | ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн зөрчлийн хураангуй мэдээлэл | 9 |


## Графикийн товьёг


| № | Гарчиг | Хуудасны дугаар |
|---|---|---|
| График 1 | ТХТХ-ийн 5-12 дугаар зүйлийн 2024 оны зөрчлийн тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулсан байдал | 8 |
| График 2 | ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 2024 оны зөрчлийн тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулсан байдал | 12 |
| График 3 | Улс болон орон нутгийн төсвийн эзлэх хувь | 14 |
| График 4 | ТХТХ-ийн зөрчилтэй болон зөрчилгүй байгууллагын 2023-2024 оны мэдээлэл | 22 |


## Хавсралтын товьёг


| № | Гарчиг | Хуудасны дугаар |
|---|---|---|
| Хавсралт 1 | ТХТХ-ийн 5-12 дугаар зүйлийн зөрчлийн мэдээлэл | 31-33 |
| Хавсралт 2 | ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн зөрчлийн мэдээлэл | 34-35 |
| Хавсралт 3 | ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтын зөрчлийн мэдээлэл | 36 |
| Хавсралт 4 | ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заалтын зөрчлийн мэдээлэл | 36 |
| Хавсралт 5 | ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалтын зөрчлийн мэдээлэл | 36 |
| Хавсралт 6 | ТХТХ-ийн 14 дүгээр зүйлийн зөрчлийн мэдээлэл | 37-40 |
| Хавсралт 7 | ТХТХ-ийн 20 дугаар зүйлийн зөрчлийн мэдээлэл | 41-44 |

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

| | |
|---|---|
| **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх** | Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв. |
| **Аудитын зорилт** | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, дүнг Үндэсний аудитын газрын Эрсдэлийн удирдлагын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:<br>• *Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан уу;*<br>• *Хөрөнгө оруулалтай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан уу;*<br>• *Засгийн газар болон бусад төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан уу.* |
| **Аудитын хамарсан хүрээ** | Аудитад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах нийслэлийн харьяа 225 байгууллагаас 67 байгууллага буюу 30 хувийг түүвэрт хамруулж, Нийслэл дэх Төрийн аудитын газраас 2024, 2025 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитын тайлангуудад тусгаж баталгаажуулсан *“Төрийн хэмнэлтийн тухай хууль”*-тай хамаарах зөрчлүүдийг аудитын тайланд нэгтгэлээ. |
| **Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт** | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт 4000 “Нийцлийн аудитын гарын авлагын ерөнхий танилцуулга”, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит.Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дугаар тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”, мөн 2022 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын дагуу аудитын зорилго, зорилт асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх зэрэг арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулав. |
| **Аудитын бүрэлдэхүүн** | Аудитыг Эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга Б.Золбаяр хянан удирдаж, ахлах аудитор Э.Отгон үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор М.Одгэрэл, А.Сэлэнгэ, Э.Ундармаа, Т.Гандолгор, М.Өлзийхишиг нар гүйцэтгэв. |

## Ерөнхий мэдээлэл

УИХ-аас 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр ТХТХ-ийг 4 бүлэг, 22 зүйлтэйгээр баталж, 2025 оны 1 дүгээр сар хүртэл 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тус хуулиар төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавих харилцааг зохицуулсан.

Аудитад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах нийслэлийн харьяа 225 байгууллагаас 67 байгууллага буюу 30 хувийг түүвэрт хамруулж, Нийслэл дэх Төрийн аудитын газраас 2024, 2025 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитын тайлангуудад тусгаж баталгаажуулсан “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-тай хамаарах зөрчлүүдийг аудитын тайланд нэгтгэсэн болно.

Нийслэлийн ЗД-ын 2023, 2024 оны төсвийн нийт зарлагыг 6,871,719.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 5,278,182.5 сая төгрөгийг зарцуулж, 183,606.9 сая төгрөгийн хэмнэлт үүсгэсэн байна.

*Хүснэгт 1. Нийслэлийн 2023-2024 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зарцуулагдаагүй үлдэгдэл | Хэмнэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 2,357,713.3 | 1,915,903.3 | 441,810.0 | 65,516.1 |
| 2 | 2024 оны нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 4,514,006.6 | 3,362,279.2 | 1,151,727.4 | 118,090.8 |
| **Нийт** | | **6,871,719.9** | **5,278,182.5** | **1,593,537.4** | **183,606.9** |

*Эх сурвалж: НТАГ-ын СНАХ-ийн 2024, 2025 онд гүйцэтгэсэн аудитын тайлан, аудитын баг.*

Аудитаар 2023 онд 610,274.2 сая төгрөг, 2024 онд 1,522,022.3 сая төгрөг, нийт 2,132,296.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

*Хүснэгт 2. Нийслэлийн 2023-2024 оны зөрчлийн мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Огноо | Зөрчлийн тоо | Зөрчлийн дүн | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | 2023 он | 596 | 610,274.2 | 252,250.0 |
| 2 | 2024 он | 1128 | 1,522,022.3 | Хугацаа болоогүй. |
| **Нийт** | | **1724** | **2,132,296.5** | **252,250.0** |

*Эх сурвалж: НТАГ-ын ГНАХ, СНАХ-ийн 2024, 2025 онд гүйцэтгэсэн аудитын тайлан, аудитын баг.*

Хүснэгтээс харахад нийслэлийн харьяа байгууллагуудын 2023 онд илэрсэн 610,274.2 сая төгрөгийн зөрчил 41.3 хувийн хэрэгжилттэй, 2024 онд илэрсэн зөрчлийн биелэлтийг тооцох хугацаа болоогүй байна.

## БҮЛЭГ А. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН УУ?

Нийслэлийн харьяа зарим байгууллагууд хуульд заасан хангамж болон хязгаарлалтыг мөрдөн ажиллах, зардлыг бууруулах, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Харин ТХТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.2-т *“Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ”* гэж заасан боловч энэхүү зохицуулалт нь бодит нөхцөл байдалд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэл үүсжээ.

## 1. ХУУЛИЙН 5-12 ДУГААР ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГАЖ АЖИЛЛАСАН УУ?

Төр, түүний бүх шатны байгууллага, ТБОНӨХЭ-ийн бүтэц, орон тоо, тээврийн хэрэгслийн ашиглалт, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, цалин хөлс, мөнгөн тэтгэмж болон бусад хангамжийн зардлын үрэлгэн байдлыг хязгаарлах зохицуулалтыг ТХТХ-ийн 5-12[1] дугаар зүйлд тусгажээ.

Аудитаар дээрх хуулийн зүйл, заалтуудын биелэлтэд хяналт хэрэгжүүлэхэд 3,067.2 сая төгрөгийн 124 зөрчил илэрсэн. */Хавсралт 1/.* Үүнийг харуулбал:

*Хүснэгт 3. ТХТХ-ийн 5-12 дугаар зүйлийн зөрчлийн мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Байгууллага | 2023 он | | 2024 он | |
|---|---|---|---|---|---|
| | | Зөрчлийн тоо | Дүн | Зөрчлийн тоо | Дүн |
| 1 | Нийслэлийн харьяа | 58 | 697.7 | 66 | 2,369.5 |

*Эх сурвалж: НТАГ-ын СНАХ-ийн 2024, 2025 онд гүйцэтгэсэн аудитын тайлан, аудитын баг.*

Нийслэлийн харьяа байгууллагуудын 2024 оны зөрчлийн тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад зөрчлийн тоо 0.6, зөрчлийн дүн 2.4 дахин нэмэгдсэн байна. Зөрчлийг хуулийн заалт тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- ***Хуулийн 5 дугаар зүйл /Тэргүүн дэд, дэд, орлогч дарга/***

Аудитын явцад 3 байгууллага ТХТХ-ийн хэрэгжилттэй холбогдуулж байгууллагын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулаагүй, оруулсан боловч тухайн албан тушаалын нэршлээс “Орлогч дарга” хэсгийг хасаж, чиг үүргийг хэвээр хадгалсан байна. Үүнд:

- *ХУБТ 2023 онд “Дэд захирал”, УБХШУЗТ ОНӨААТҮГ нь 2023-2024 онд “Ерөнхий диспетчер”;*
- *ХИХУГ ОНӨААТҮГ нь 2024 оны А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог өөрчилсөн боловч "Орлогч-дарга-Ерөнхий инженер" албан тушаалын нэршлийг өөрчилж "Ерөнхий инженер" болгон орон тоог хэвээр хадгалсан нь ТХТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.4[2] дэх заалттай нийцээгүй байна.*

- ***Хуулийн 6 дугаар зүйл /Тээврийн хэрэгсэл/***

---

[1] *5 дугаар зүйл.Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 6 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйл.Албан тасалгаа, 8 дугаар зүйл.Дүрэмт хувцас, 9 дүгээр зүйл.Албан томилолт, 10 дугаар зүйл.Цалин хөлс, нэмэгдэл, 11 дүгээр зүйл.Нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 12 дугаар зүйл.Бусад хангамж;*

[2] *5.4.Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно.*

Нийслэлийн ЗД-ын 2022 оны А/789[3] дүгээр захирамжаар нийслэлийн харьяа байгууллагуудын 107 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлж, А/1279[4] дүгээр захирамжаар 22 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдан борлуулсан байна.

Нийслэлийн ИТХ-ын дарга, ЗД-аас бусад 4 байгууллагын 29 удирдах албан тушаалтан суудлын автомашиныг албан хэрэгцээнд болон захиргааны үйл ажиллагаанд ашиглаж 308.8 сая төгрөг, бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй 20 байгууллагын 49 зөрчил, нийт 24 байгууллагын 308.8 сая төгрөгийн 78 зөрчил илэрсэн нь ТХТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4 дэх заалттай тус тус нийцээгүй байна.

*Хүснэгт 4. Нийслэлийн харьяа байгууллагуудын ТХТХ-ийн 6 дугаар зүйлийн зөрчлийн мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Хуулийн зүйл, заалт / Байгууллагын ангилал | 6.2 | | 6.4 | |
|---|---|---|---|---|---|
| | | **Зөрчлийн тоо** | **Дүн** | **Зөрчлийн тоо** | **Дүн** |
| **1** | ТШЗ | 28 | 306.9 | 41 | - |
| **2** | ТБОНӨХЭ | 1 | 1.9 | 8 | - |
| **Нийт** | | **29** | **308.8** | **49** | - |

*Эх сурвалж: НТАГ-ын СНАХ-ийн 2024, 2025 онд гүйцэтгэсэн аудитын тайлан, аудитын баг.*

Тухайлбал:

- *Нийслэлийн ЗДТГ-ын харьяа 26 нэгж /2023 онд 12, 2024 онд 14/-ийн удирдах албан тушаалтан, мөн НАОБТГ, НХХААГ, УБХХОМ ҮЦК ХК-ийн захирал, дарга нар суудлын автомашиныг албан хэрэгцээ болон захиргааны үйл ажиллагаанд ашигласан нь ТХТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2[5]дахь заалт,*



- *2023 онд НБОГ, ННҮГ, ХИХУГ ОНӨААТҮГ, УБ лифт ОНӨААТҮГ зэрэг 18 байгууллагын 25 тээврийн хэрэгсэл, 2024 онд ХУД-ийн ЗДТГ, Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ зэрэг 2 байгууллагын 5 тээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй нь ТХТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4[6] дэх заалттай нийцээгүй байна.*



## ***Хуулийн 8 дугаар зүйл /Дүрэмт хувцас/***

Тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2[7]-т зааснаас бусад чиг үүргийн дараах байгууллагууд төсвийн 4.5 сая төгрөгөөр албан хаагчдад хувцас худалдан авсан байна. Тухайлбал:

- *2023 онд СБД-ийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв 2.5 сая төгрөгөөр өвөл, зуны ажлын хувцас,*

---

*[3] Нийслэлийн ЗД-ын 2022.06.09-ний өдөр баталсан "Хуулийн хэрэгжилтийг хангах тухай зарим арга хэмжээний тухай" захирамж,*

*[4] Нийслэлийн ЗД-ын 2022.10.05-ны өдөр баталсан "Нийслэлийн өмчийн бүртгэлээс тээврийн хэрэгсэл хасах, балансаас балансад шилжүүлэх тухай" захирамж,*

*[5] 6.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.*

*[6] 6.4.Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.*

*[7] 8.2.Энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас хамаарахгүй.*

- *2024 онд БХД-ийн Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ 2.0 сая төгрөгөөр албан хаагчдад гадуур хувцас худалдан авсан нь ТХТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1[8] дэх заалттай нийцээгүй байна.*

## ***Хуулийн 9 дүгээр зүйл /Албан томилолт/***

Төр, түүний бүх шатны байгууллага, ТБОНӨХЭ-ийн албан хаагч гадаад улсад албан томилолтоор ажиллахдаа нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ гэж заасан. Гэтэл 2023-2024 онд 19 байгууллага албан хаагчдыг гадаад улсад албан томилолтоор ажиллуулахдаа бусад агаарын тээвэрлэгчийг сонгон, нийт 1,652.7 сая төгрөгийн тасалбар худалдан авсан байна. Жишээлбэл:

- *2023 онд НД-ийн ИТХ 12.4 сая төгрөг,*
- *2024 онд СХД-ийн ЗДТГ 364.7 сая төгрөг, ИТХ 5.5 сая төгрөг, СБД-ийн ЗДТГ 313.9 сая төгрөг, ИТХ 147.0 сая төгрөг, Нийслэлийн ЗДТГ 244.3 сая төгрөг, БГД-ийн ЗДТГ 135.7 сая төгрөг, Нийслэлийн ИТХ 84.0 сая төгрөг, ЭЭАУП ОНӨААТҮГ 9.5 сая төгрөг, УБХК ОНӨГ 8.1 сая төгрөг.*

Дээрх нөхцөл байдал нь тухайн үед үндэсний агаарын тээвэрлэгчийн тасалбар дууссан, эсвэл бусад агаарын тээвэрлэгчийн тасалбар нь үнийн хувьд хямд байсан, мөн зарим тохиолдолд тасалбар худалдан авахад тодорхой хувийн хөнгөлөлттэй байсан зэрэг шалтгаанаар бусад агаарын тээвэрлэгчийг сонгожээ.

ТХТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.2-т *"Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ"* гэж заасан боловч энэхүү зохицуулалт нь бодит нөхцөл байдалд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэл үүсжээ.

## ***Хуулийн 10 дугаар зүйл /Цалин хөлс, нэмэгдэл/***

Багачууд хүнс ОНӨААТҮГ-ын захирлын 2023 оны А/01, А/13 дугаар тушаалаар албан хаагчдын цалинг тогтоосон нь ТХТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1-т *"Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг …орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно"* гэж заасантай нийцээгүй байна.

## ***Хуулийн 12 дугаар зүйл /Бусад хангамж/***

ТХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1-*т "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно"* гэж заасан.

Гэвч 2023-2024 онд байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоогүй гар утасны зардалд 2 байгууллага 0.7 сая төгрөг, хэвлэл захиалгын төлбөрт 4 байгууллага 59.1 сая төгрөг, зөвшөөрөөгүй бусад зардалд 14 байгууллага 1,041.4 сая төгрөг, нийт 20 байгууллага 1,101.2 сая төгрөгийг хуулиар хориглосон зардлуудад зарцуулсан нь ТХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 12.1.4 дэх заалтуудтай нийцээгүй байна.

---

*[8] 8.1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.*

*Хүснэгт 5. Нийслэлийн харьяа байгууллагуудын ТХТХ-ийн 12 дугаар зүйлийн зөрчлийн мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Хуулийн зүйл, заалт / Байгууллагын ангилал | 12.1.1 | | 12.1.3 | | 12.1.4 | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Зөрчлийн тоо** | **Дүн** | **Зөрчлийн тоо** | **Дүн** | **Зөрчлийн тоо** | **Дүн** |
| **1** | ТШЗ | - | - | 4 | 59.1 | 11 | 889.0 |
| **2** | ТБОНӨХЭ | 2 | 0.7 | - | - | 3 | 152.4 |
| **Нийт** | | **2** | **0.7** | **4** | 59.1 | **14** | **1,041.4** |

*Эх сурвалж: НТАГ-ын СНАХ-ийн 2024, 2025 онд гүйцэтгэсэн аудитын тайлан, аудитын баг.*

Тухайбал:



*• 2023 онд Асгат хүнс ОНӨААТҮГ 0.3 сая төгрөг, СХД-ийн Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ 0.4 сая төгрөг, нийт 0.7 сая төгрөгийн бусад гар утасны төлбөр төлсөн нь ТХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.1[9] дэх заалт,*

*• 2024 онд СХД-ийн ЗДТГ 27.5 сая төгрөгөөр архивын сургалтын заавар журмын эмхэтгэл, олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах сургалтад зориулж гарын авлага хэвлүүлсэн, СХД-ийн ИТХ 26.5 сая төгрөг, ХУД-ийн ЗДТГ 4.5 сая төгрөг, Нийслэлийн ИТХ 3.1 сая төгрөгөөр хэвлэл захиалсан нь ТХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.3[10] дахь заалт,*

*• 2023 онд Нийслэлийн ИТХ-ын 51 төлөөлөгч /давхардсан тоогоор/-ийг 321.9 сая төгрөг, ХУД-ийн ИТХ-ын 12 төлөөлөгчийг 88.7 сая төгрөгөөр гадаад улсад сургалт, хурал, хэлэлцүүлэгт оролцуулах болон албан айлчлал, туршлага судлуулах зорилгоор томилолтын зардал гаргасан нь чадавхжуулах зардалтай давхардуулан олгосон, НД-ийн ИТХ төсвөөс улс төрийн намуудад намын суудлын 42.0 сая төгрөг олгосон,*

*• 2024 онд ХУД-ийн ЗДТГ 50.4 сая төгрөг /Тахилгын ёслол хийж зардал гаргасан, амны хаалт их хэмжээгээр худалдан авсан/-ийн зардал, БНД-ийн ИТХ чадавхжуулах арга хэмжээний нийтлэг жишгийг мөрдөж ажиллаагүйгээс 31.2 сая төгрөгийн зардлыг гаргасан нь ТХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.4[11] дэх заалттай тус тус нийцэхгүй байна.*

Нийслэлийн харьяа байгууллагуудын 2024 оны зөрчлийн тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад хуулийн 6, 8, 10 дугаар зүйлийн зөрчил буурсан бол харин 5, 9 дүгээр зүйлийн зөрчил өссөн үзүүлэлттэй байна.

*График 1. ТХТХ-ийн 5-12 дугаар зүйлийн 2024 оны зөрчлийн тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулсан байдал*



| | 5-р зүйл | 6-р зүйл | 8-р зүйл | 9-р зүйл | 10-р зүйл | 12-р зүйл |
|---|---|---|---|---|---|---|
| 2023 он | 1 | 43 | 2 | 1 | 1 | 10 |
| 2024 он | 2 | 35 | 1 | 18 | 0 | 10 |

*Эх сурвалж. Аудитын баг.*

*[9] 12.1.1.үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал;*
*[10] 12.1.3.хэвлэлийн захиалгын төлбөр;*
*[11] 12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад.*

Аудитын явцад *“ТХТХ-ийн 5-12 дугаар зүйл буюу Төр, түүний бүх шатны байгууллага, ТБОНӨХЭ-ийн тэргүүн дэд, дэд, орлогч даргын орон тоо, тээврийн хэрэгслийн ашиглалт, захиргааны зориулалтаар барилга шинээр барих, албан тасалгаа, албан хаагчдын дүрэмт хувцас, албан томилолт, цалин хөлс, түүний нэмэгдэл, нэг удаагийн мөнгөн тэтгэмж болон бусад хангамжийн үрэлгэн байдлыг хязгаарлах зохицуулалт хангалттай байна уу?”* асуулгад 19 байгууллага буюу 19.8 хувь нь “Хангалттай бус”, “Хангалтгүй”, *“Төрийн хэмнэлтийн тухай хуулийг цаашид хэрэгжүүлэхэд таны санал, зөвлөмж”* асуулгад 26 саналаас 3 санал буюу 11.5 хувь нь “ТХТХ-ийн 5, 6, 9 дүгээр зүйлийн эрх зүйн зохицуулалтыг эргэн харах” хариултыг өгч, дараах шалтгааныг дурдсан байна. Үүнд:

- *Одоогийн мөрдөгдөж буй хуулийн зүйл, заалт нь бодит байдалд байгууллагын үйл ажиллагааны чиглэл, онцлогтой нийцээгүй, зөрчилдөх тохиолдол гарч байгаа нь зохицуулалтын уян хатан бус байдал, нийтлэг байдлаар томъёолсон заалтуудтай холбоотой. Иймд байгууллагын үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн, илүү тодорхой, уян хатан зохицуулалт бүхий эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй байна.*

***ДҮГНЭЛТ: НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯА ЗАРИМ БАЙГУУЛЛАГУУД ХУУЛЬД ЗААСАН ХАНГАМЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯЗГААРЛАЛТЫГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.***

## 2. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД ХЭМНЭЛТИЙН БУСАД АРГА ХЭМЖЭЭГ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛСАН УУ?

ТХТХ-ийн 15 дугаар зүйлд төсвийн байгууллага, ТБОНӨХЭ-ийн баримтлах хэмнэлтийн бусад арга хэмжээг заасан бөгөөд аудитаар тус зүйл, заалттай холбоотой 5,759.8 сая төгрөгийн 82 зөрчил илэрсэн. */Хавсралт 2/.*

*Дүрслэл 1. ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн зөрчлийн хураангуй мэдээлэл*

*/сая.төг/*




*Эх сурвалж: Аудитын баг.*

### <u>*Хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалт*</u>

ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1-т *“Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”* гэж заасан.

Гэвч хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэр /тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг/-ээр олгосон 310.1 сая төгрөг, төр, түүний бүх шатны байгууллагын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд

хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор зарцуулсан 99.6 сая төгрөг, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан 421.2 сая төгрөг, нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэж, нөөцөлсөн 544.4 сая төгрөг, нийт 1,375.3 сая төгрөгийн зардлыг хэмнээгүй байна.

*Хүснэгт 6. Нийслэлийн харьяа байгууллагуудын ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын зөрчлийн мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Хуулийн зүйл, заалт / Байгууллагын ангилал | 15.1.3 | | 15.1.4 | | 15.1.5 | | 15.1.6 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зөрчлийн тоо | Дүн | Зөрчлийн тоо | Дүн | Зөрчлийн тоо | Дүн | Зөрчлийн тоо | Дүн |
| **1** | ТШЗ | 7 | 288.5 | 1 | - | 14 | 401.9 | 10 | 133.9 |
| **2** | ТБОНӨХЭ | 3 | 21.6 | 2 | 99.6 | 5 | 19.3 | 4 | 410.5 |
| **Нийт** | | **10** | **310.1** | **3** | **99.6** | **19** | **421.2** | **14** | **544.4** |

*Эх сурвалж: НТАГ-ын СНАХ-ийн 2024, 2025 онд гүйцэтгэсэн аудитын тайлан, аудитын баг.*

Тухайлбал:

- *2023 онд БХД-ийн ЗДТГ чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэхэд оролцсон албан хаагчдад 6.5 сая төгрөг, ДАА нь 2023 оны 6-12 дугаар сард 3 албан хаагчийг тус бүр 1.5 сарын цалингаар шагнаж урамшуулан 5.7 сая төгрөгийн дэмжлэг олгосон,*
- *2024 онд ЧД-ийн ЗДТГ хорооны ахмадын дарга нарт 2 удаа 60.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн, тус ахмадын хороогоор дамжуулан ахмад настнуудад анхан шатны эрүүл мэндийн үзлэг хийсний төлбөрт 96.0 сая төгрөгийг олгосон нь ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.3[12] дахь заалт,*
- *2023 онд Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ үйл ажиллагааг сурталчлан таниулах үйл ажиллагаанд 39.1 сая төгрөг, нэвтрүүлэг контентын зардалд 11.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.4[13] дэх заалт,*
- *2023 онд БГД-ийн ЗДТГ 46.8 сая төгрөг, БЗД-ийн ЗДТГ 35.4 сая төгрөг, Хот тохижилтын газар 29.0 сая төгрөг, СХД-ийн ЗДТГ 18.4 сая төгрөг, ЭЭАҮП ОНӨААТҮГ 4.0 сая төгрөг, Хот байгуулалт, хөгжлийн газар 3.9 сая төгрөг,*
- *2024 онд Нийслэлийн ИТХ дотоод томилолтын зардлаас 1.2 сая төгрөгийн үнэ бүхий бэлэг дурсгалын зүйлийг төсвийн болон байгууллагын хөрөнгөөр худалдан авсан нь ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.5[14] дахь заалт,*
- *2023 онд УСУГ ОНӨААТҮГ 340.2 сая төгрөг, ЭЭАҮП ОНӨААТҮГ 39.6 сая төгрөг, НАОБТГ 14.5 сая төгрөгийн хэрэглэгдэхгүй тоног төхөөрөмж, БГД-ийн ЗДТГ 5.7 сая төгрөгийн даавуун тор нөөцөлсөн,*
- *2024 онд Нийслэлийн ИТХ 36.4 сая төгрөгийн ном, эмхэтгэл, СХД-ийн ИТХ 17.6 сая төгрөгөөр их хэмжээгээр бараа материал худалдан авч нөөцөлсөн нь ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.6[15] дахь заалттай тус тус нийцэхгүй байна.*

## ***Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт***

ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т *“Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана”* гэж заасан.

*[12] 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;*
*[13] 15.1.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;*
*[14] 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;*
*[15] 15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;*

Гэвч барилга байгууламжид дулааны тоолуур ашиглаж, хэмнэлтийн горимд шилжүүлээгүй 3 зөрчил, сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулаагүй, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнээгүй 662.0 сая төгрөг, өр төлбөр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй 3,692.6 сая төгрөг, байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай уялдуулаагүй 30.0 сая төгрөг, нийт 4,384.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь хэмнэлтийн горим болон хуульд заасан арга хэмжээг авч ажиллаагүйгээс шалтгаалжээ.

*Хүснэгт 7. Нийслэлийн харьяа байгууллагуудын ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтын зөрчлийн мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Хуулийн зүйл, заалт / Байгууллагын ангилал | 15.2.2 | | 15.2.3 | | 15.2.5 | | 15.2.6 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зөрчлийн тоо | Дүн | Зөрчлийн тоо | Дүн | Зөрчлийн тоо | Дүн | Зөрчлийн тоо | Дүн |
| 1 | ТШЗ | 1 | - | 7 | 623.5 | 1 | 426.4 | 1 | 30.0 |
| 2 | ТБОНӨХЭ | 2 | - | 5 | 38.5 | 2 | 3,266.2 | 2 | - |
| **Нийт** | | **3** | **-** | **12** | **662.0** | **3** | **3,692.6** | **3** | **30.0** |

*Эх сурвалж: НТАГ-ын СНАХ-ийн 2024, 2025 онд гүйцэтгэсэн аудитын тайлан, аудитын баг.*

Тухайлбал:




- *2023 онд ХИХУГ ОНӨААТҮГ, НД-ийн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 7, ХУД-ийн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 25, нийт 32 барилга байгууламжид дулааны тоолуур ашиглаж, хэмнэлтийн горимд шилжүүлээгүй нь ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2.2[16] дахь заалт,*
- *2023 онд БГД-ийн ЗДТГ байрны түрээсийн төлбөрийг өмнөх оны гүйцэтгэлээс 443.4 сая төгрөг, гадаад албан томилолтын зардлыг 66.6 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан, Эрдэнэс Баянбогд ХХК үр дүн нь тодорхойгүй 2 сургалтыг танхимаар зохион байгуулж 18.0 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан, БГД-ийн ДАА сургалтад зориулан 10.8 сая төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулсан, Хан-Уул Агро ОНӨААТҮГ 1.4 сая төгрөг, Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ 7.4 сая төгрөгийг тушаал, шийдвэргүйгээр томилолтын зардалд зарцуулсан зэрэг нь ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2.3[17] дахь заалт,*
- *2024 онд Нийслэлийн ИТХ 426.4 сая төгрөг, СХД-ийн Захиалагчийн алба 3,094.4 сая төгрөгийн өр төлбөр, УСУГ ОНӨААТҮГ 171.8 сая төгрөгийн авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллагаагүй нь ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2.5[18] дахь заалт,*
- *ХИХУГ ОНӨААТҮГ 2023 онд үр дүнгийн үнэлгээ, гүйцэтгэлийг тооцож, үнэлж баталгаажуулсан үнэлгээний хуудасгүйгээр эхний хагас жилд албан хаагчдад 30.0 сая төгрөгийн улирлын урамшуулал олгосон, 2024 онд ажлын үр дүнг үнэлэх шалгууртай нийцүүлэлгүйгээр албан хаагчдад сар бүр 10-20 хувийн урамшуулал олгосон, мөн 30 хүний орон тоотой "Орон сууц, ашиглалтын хэлтэс" үйл ажиллагаа явуулаагүй нь ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2.6[19] дахь заалттай тус тус нийцээгүй байна.*

---

*[16] 15.2.2.нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;*
*[17] 15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;*
*[18] 15.2.5.хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх;*
*[19] 15.2.6.байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.*

Нийслэлийн харьяа байгууллагуудын 2024 оны зөрчлийн тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын зөрчил 1.2 дахин өссөн, 15.2 дахь заалтын зөрчил 3.1 дахин буурсан байна.

*График 2. ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн 2024 оны зөрчлийн тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулсан байдал*




*Эх сурвалж. Аудитын баг*

Аудитын явцад *“...ТХТХ-ийн 15 дугаар зүйл буюу Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглох зүйлс болон авч хэрэгжүүлэх хэмнэлтийн бусад арга хэмжээг мөрдөж чадаж байна уу?”* асуулгад 8 байгууллага буюу 8.3 хувь нь “Хангалттай бус”, “Хангалтгүй”, *“Төрийн хэмнэлтийн тухай хуулийг цаашид хэрэгжүүлэхэд таны санал, зөвлөмж”* асуулгад 26 саналаас 2 санал буюу 7.7 хувь нь “ТХТХ-ийн 15 дугаар зүйлийн эрх зүйн зохицуулалтыг эргэн харах” хариултыг өгсөн байна.

***ДҮГНЭЛТ: НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯАНЫ ЗАРИМ БАЙГУУЛЛАГУУД ХЭМНЭЛТИЙН ГОРИМЫГ БАРИМТЛААГҮЙ, ҮЙЛ АЖИЛЛАГААГАА БАГА ЗАРДЛААР ӨНДӨР ҮР ДҮНГ ХАНГАХАД ЧИГЛҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.***

## БҮЛЭГ Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬД ЗААСАН ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН УУ?

ТХТХ-иар ТАХ-ний жагсаалтад тусгах, санхүүжүүлэхийг хориглосон заалтыг зөрчсөн, мөн ТАХ-ний хэрэгжилтийг зохион байгуулахтай холбоотой зарим журмыг баримтлаагүйгээс хэрэгжилт хангалтгүй байна.

- *2023-2024 онд төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 1792 ТАХ-ний ХАА-г зохион байгуулж, 103,021.6 сая төгрөгийн хэмнэлт үүссэн болович үүний 21.7 хувийг зарцуулсан байна.*

Нийслэлийн харьяа зарим байгууллагууд цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх шаардлагатай байна.

## 1. ХУУЛИЙН 13 ДУГААР ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГАЖ АЖИЛЛАСАН УУ?

ТХТХ-ийн 13[20] дугаар зүйлд ТАХ-ний хэрэгжилтийг зохион байгуулах журам болон ТАХ-ний жагсаалтад тусгах, санхүүжүүлэхийг хориглосон зүйлсийг заажээ.

Монгол Улсын 2023, 2024 оны төсвийн тухай хууль /Нийслэлийн ЗД-д эрх шилжсэн/, нийслэл, дүүргийн ИТХ-ын төсөв батлах тухай тогтоолоор нийт 7,045,496.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2555 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

*Хүснэгт 8. Монгол Улсын 2023, 2024 оны төсвийн тухай хууль /Нийслэлийн ЗД-д эрх шилжсэн/ болон нийслэл, дүүргийн ИТХ-ын тогтоолоор баталсан ТАХ-ний хураангуй мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Эх үүсвэр | Нийт ТАХ-ний | | Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний | |
|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Төсөвт өртөг | Тоо | Төсөвт өртөг |
| 1 | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль /Нийслэлийн ЗД-д эрх шилжсэн/ | 170 | 886,022.5 | 7 | 381,318.9 |
| 2 | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль /Нийслэлийн ЗД-д эрх шилжсэн/ | 142 | 1,038,127.9 | 60 | 307,456.4 |
| **Нийт** | | **312** | **1,924,150.4** | **67** | **688,775.3** |
| 3 | Нийслэлийн ИТХ-ын 2023 оны төсөв батлах тухай тогтоол | 397 | 1,841,320.3 | 85 | 71,502.8 |
| 4 | Нийслэлийн ИТХ-ын 2024 оны төсөв батлах тухай тогтоол | 456 | 2,407,453.1 | 130 | 726,696.4 |
| **Нийт** | | **853** | **4,248,773.4** | **215** | **798,199.2** |
| 5 | Дүүргийн ИТХ-ын 2023 оны төсөв батлах тухай тогтоол | 574 | 310,312.8 | 320 | 169,844.4 |
| 6 | Дүүргийн ИТХ-ын 2024 оны төсөв батлах тухай тогтоол | 816 | 562,259.4 | 513 | 338,013.6 |
| **Нийт** | | **1390** | **872,572.2** | **833** | **507,858.0** |
| **Нийт дүн** | | **2555** | **7,045,496.0** | **1115** | **1,994,832.5** |

*Эх сурвалж: "Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн", "Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт" сэдэвт гүйцэтгэл, нийцлийн аудит болон нийслэл, дүүргийн ИТХ-ын 2023, 2024 оны төсөв батлах тухай тогтоол*

[20] *13 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ*

*График 3. Улс болон орон нутгийн төсвийн эзлэх хувь*

*/сая.төг/*




Хүснэгтээс харахад 2023-2024 онд шинээр хэрэгжүүлэх нийт 1,994,832.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1115 ТАХ-ний 34.5 хувийг улсын төсөв, 40.0 хувийг нийслэлийн төсөв, 25.5 хувийг дүүргийн төсөв тус тус эзэлж байна.

Аудитаар улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г зохион байгуулахад зохих журмыг баримталсан эсэх, тэдгээрийн төлөвлөгөөнд хориглосон зүйлсийг тусгасан эсэх, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ нь төлөвлөлтийн шаардлагыг хангасан эсэхэд хяналт хэрэгжүүлэхэд дараах байдалтай байна. Үүнд:

***<u>Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт /Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална/</u>***

Төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд шинээр хэрэгжүүлэх 1,994,832.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1115 ТАХ-г баталсан ч ТАХ-г багцад задалж хуваах, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг шалтгаанаар нэмэгдүүлж, 2,444,598.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1792 ТАХ-ний ХАА-гааг зохион байгуулсан байна.

ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтад *“хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх”* гэж заасан бөгөөд дээрх 1792 ХАА-аас 103,021.6 сая төгрөгийн хэмнэлт үүсгэсэн боловч 22,365.6 сая төгрөгийг зарцуулжээ.

*Хүснэгт 9. Улс, орон нутгийн 2023, 2024 оны ХАА-ны мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Огноо | Эх үүсвэр | Амжилттай зохион байгуулсан ХАА-ны | | | Хэмнэлтийн дүн | Хэмнэлтээс зарцуулсан дүн |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Тоо | Төсөвт өртөг | Гэрээний дүн | | |
| 1 | 2023 он | Улсын төсөв | 8 | 396,991.9 | 396,538.4 | 453.5 | - |
| | | Орон нутгийн төсөв | 656 | 418,353.7 | 411,366.0 | 7,277.6 | 103.3 |
| 2 | 2024 он | Улсын төсөв | 58 | 139,231.7 | 134,664.4 | 4,567.3 | - |
| | | Орон нутгийн төсөв | 1070 | 1,490,020.7 | 1,420,155.2 | 90,723.2 | 22,262.3 |
| **Нийт** | | | **1792** | **2,444,598.0** | **2,362,724.0** | **103,021.6** | **22,365.6** |

*Эх сурвалж: Аудитын баг*

Хүснэгтээс харахад 2023, 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр зохион байгуулсан ХАА-ны хэмнэлтийн дүн 21,144.7 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- *ХУД-ийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжих “Явган зам тавих, засварлах ажил” ТАХ-ий гэрээний дүнг төсөвт өртгөөс 255.1 сая төгрөг,*

*• Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжих “151 дүгээр сургуулийн урд 3 айлын газар чөлөөлж авто зогсоол барих (СХД, 9 дүгээр хороо)” ТАХ-ний гэрээний дүнг төсөвт өртгөөс 34.8 сая төгрөг,*

*• Үнэт цаасны хөрөнгөөр 2024 онд хэрэгжих “Наадамчдын авто замаас Энхтайвны өргөн чөлөө хүртэлх авто замын ажил (2 дугаар хэсэг)” ТАХ-ний гэрээний дүнг төсөвт өртгөөс 17,278.1 сая төгрөг,*

*• ЧД-ийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих “Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн салбар ангийн барилга барих” ТАХ-ний гэрээний дүнг төсөвт өртгөөс 2,595.0 сая төгрөг,*

*• Нийслэлийн Замын сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих “Авто зам, замын байгууламжийн барилга, засвар шинэчлэлтийн ажлын зураг төсөл, зөвлөх үйлчилгээ” ТАХ-ний гэрээний дүнг төсөвт өртгөөс 504.6 сая төгрөг,*

*• Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих “Ерөнхий боловсролын сургуулиудын ариун цэврийн өрөөний тохижилт, засварын ажил (БГД)” ТАХ-ний гэрээний дүнг төсөвт өртгөөс 477.1 сая төгрөгөөр тус тус илүү дүнгээр байгуулсан байна.*

ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т “*төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх*” гэж заасныг зөрчин, нийт 65,134.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 104 ТАХ-г хугацаанд нь хэрэгжүүлэх боломжгүй нөхцөлд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. */Хавсралт 3/.*

*Хүснэгт 10. ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтын зөрчлийн мэдээлэл*

/сая.төг/

| № | Эх үүсвэр | 2023 оны зөрчилтэй | | 2024 оны зөрчилтэй | |
|---|---|---|---|---|---|
| | | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | ТАХ-ний тоо | Төсөвт өртөг |
| 1 | Улсын төсөв | - | - | 16 | 16,118.1 |
| 2 | Нийслэлийн төсөв | 33 | 4,097.8 | 22 | 32,074.0 |
| 3 | Дүүргийн төсөв | 33 | 12,844.3 | - | - |
| **Нийт** | | **66** | **16,942.1** | **38** | **48,192.1** |

*Эх сурвалж: НТАГ-ын ГНАХ-ийн 2024, 2025 онд гүйцэтгэсэн аудитын тайлан.*

Хүснэгтээс харахад зөрчлийн дүнгийн 25.0 хувийг улс, 75.0 хувийг орон нутгийн төсөв эзэлж байгаа бөгөөд дараах ТАХ-д тухайн онуудад хэрэгжиж дуусаагүй байна. Тухайлбал:

*• Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх 3,968.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дүүргийн хатуу хучилттай авто зам, замын шинэчлэл, гүүрэн байгууламж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” ТАХ-ний гэрээг 2024.06.06-ны өдөр, 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн тээврийн автобусны буудлын тохижилт, шинэчлэл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/” ТАХ-ний гэрээг 2024.07.16-ны өдөр, 4,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Уулзваруудын нэвтрэх чадварыг сайжруулах талаар техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах” ТАХ-ний гэрээг 2024.11.25-ны өдөр,*

*• Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх 343.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Их тэнгэр цогцолбор”-ын баруун шалган нэвтрүүлэх цэгээс тусгай объект хүртэлх авто зам, зогсоолыг засварлаж, шинээр асфальт бетон хучилт хийлгэх ажил” ТАХ-ний гэрээг 2023.10.05-ны өдөр, 360.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Барилгын засвар (Хан-Уул дүүрэг, 8 дугаар хороо, 209 дүгээр цэцэрлэг)” ТАХ-ний гэрээг 2023.10.13-ны өдөр,*

*• 2024 онд хэрэгжүүлэх 4,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “СХД, 32 хороо, Хурганы зам (Эмээлтийн авто замаас шинэ цэцэрлэг хүртэл)” ТАХ-ний гэрээг 2024.10.10-ны өдөр, 6,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл"-ийн 2 дугаар шугам буюу "Яармаг, Нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн цогцолбор-Хархорин захын автобусны буудал" чиглэлийн хоёр зогсоол болон зарим тулгуур багануудын гадна тохижилт, зураг төсөл, инженерийн дэд бүтцийн ажил” ТАХ-ний гэрээг 2024.11.14-ний өдөр,*

*• Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд ХУД-т хэрэгжих 856.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Явган хүний зам талбайн засвар, шинэчлэл /11, 19, 20-р хороо/” ТАХ-ний гэрээг 2023.10.03-ны өдөр, ЧД-т хэрэгжих “Чингисийн хүрээний авто замаас эко ахмадын сувилал хүртэлх авто замын ажил” ТАХ-ний гэрээг 2023.12.20-ны өдөр, 3,526.6 сая*

*төгрөгийн төсөвт өртөгтэй "Чингисийн хүрээний авто замаас эко ахмадын сувилал хүртэлх авто замын ажил" ТАХ-ний гэрээг 2023.12.20-ны өдөр, 2,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Хорооны цогцолбор барилга барих" ТАХ-ний гэрээг 2023.12.15-ны өдөр байгуулсан байна.*

## ***Хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заалт***

ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3-т *"Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно"* гэж заасан.

Гэвч улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй 55,451.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 105 ТАХ, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй буюу төлөвлөлтийн шаардлага хангаагүй 1,173,082.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 580 ТАХ, нийт 1,228,534.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 685 ТАХ-г тусгаж баталсан зөрчил илэрсэн. */Хавсралт 4/.*

*Хүснэгт 11. ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заалтын зөрчлийн мэдээлэл*

/сая.төг/

| № | Хуулийн зүйл, заалт / Эх үүсвэр | 2023 он | | | | 2024 он | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 13.3.2 | | 13.3.3 | | 13.3.2 | | 13.3.3 | |
| | | Зөрчилтэй ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Зөрчилтэй ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Зөрчилтэй ТАХ-ний тоо | Төсөвт өртөг | Зөрчилтэй ТАХ-ний тоо | Төсөвт өртөг |
| **1** | Улсын төсөв | - | - | 4 | 48,523.1 | 1 | 2,000.0 | 60 | 307,456.1 |
| **2** | Нийслэлийн төсөв | - | - | 24 | 75,630.1 | 9 | 9,000.0 | 117 | 410.011.9 |
| **3** | Дүүргийн төсөв | 17 | 4,507.3 | 138 | 113,533.6 | 78 | 39,944.5 | 237 | 217,927.5 |
| **Нийт** | | **17** | **4,507.3** | **166** | **237,686.8** | **88** | **50,944.5** | **414** | **935,395.5** |

*Эх сурвалж: НТАГ-ын ГНАХ-ийн 2024, 2025 онд гүйцэтгэсэн аудитын тайлан.*

Хүснэгтээс харахад зөрчлийн дүнгийн 29.0 хувийг улс, 71.0 хувийг орон нутгийн төсөв эзэлж байна. Тухайлбал:

## ***ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3.2 дахь заалт***

- *Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх 2,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Агаарын бохирдлыг бууруулах тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянгол дүүрэг)" ТАХ,*
- *Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх 1,510.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Нийтийн зориулалтай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэлт (БЗД)", 1,315.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Нийтийн зориулалтай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэлт (БГД)", 1,091.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "81/1 дүгээр байрны гадна фасад засвар (Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Их тойруу)" ТАХ,*
- *Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд ХУД-т хэрэгжих 1,167.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга, фасад засвар /12, 13-р хороо/", 800.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга, фасад засвар /2, 3, 17-р хороо/" ТАХ,*
- *2024 онд СБД-т хэрэгжих 2,403.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "3-р хороо, нийтийн зориулалттай орон сууцны фасад засвар", БГД-т хэрэгжих 2,295.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Фасад засварын ажил Багц-4" ТАХ нь хувийн өмчид шилжих, улсын болон орон*

*нутгийн өмчид бүртгэх боломжгүй буюу ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3.2[21] дахь заалттай нийцээгүй байна.*

## ***ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3.3 дахь заалт***

- *Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх 37,896.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Нийтийн тээврийн автопарк /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/", 7,626.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Нийтийн тээврийн автопаркийн гадна дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/" ТАХ,*
- *2024 онд хэрэгжүүлэх 40,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Эмнэлгийн барилга худалдан авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 32 дугаар хороо/", 24,976.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сургуулийн барилга, 1500 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 38 дугаар хороо, Баганат хороолол/", 22,950.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Дүүргийн хатуу хучилттай авто зам, замын шинэчлэл, гүүрэн байгууламж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/", 19,113.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Өвлийн спортын ордны барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/" ТАХ,*
- *Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх 21,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтөд ороогүй айл өрхүүдийн цахилгаан халаагуур (Улаанбаатар хот), Гэр", 7,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтөд ороогүй айл өрхүүдийн цахилгаан халаагуур (Улаанбаатар хот), Байшин", 2,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Энхтайваны өргөн чөлөөний авто замын нийтийн тээврийн 1 дүгээр эгнээний хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (5-н шарын уулзвараас Офицеруудын ордоны тойрог)", 1,524.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Чингисийн өргөн чөлөөний авто замын хэсэгчилсэн шинэчлэлт (СБД, Төв шуудангийн уулзвараас урагш Энхтайваны гүүр)" ТАХ,*
- *2024 онд хэрэгжүүлэх 20,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Ухаалаг Улаанбаатар "Смарт сити" төсөл", 20,058.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Найрамдлын авто замын засвар, шинэчлэлт. (Тахилтын уулзвараас Найрамдал зуслан )" ТАХ,*
- *Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд СБД-т хэрэгжих 9,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Дүүргийн нутаг дэвсгэрт цэцэрлэгт хүрээлэн, спорт цогцолбор барих, газар чөлөөлөх", ХУД-т хэрэгжих 2,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга фасад засвар /нисэхийн бүс/", БЗД-т хэрэгжих 2,752.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга, спорт заал, тохижилтын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)", 2,699.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Гэрэлтүүлгийн ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг)", ЧД-т хэрэгжих 2,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Хорооны цогцолбор барилга барих" ТАХ,*
- *2024 онд ХУД-т хэрэгжих 11,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "7 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгыг буулгаж өргөтгөлийн барилга барих (16 дугаар хороо)", БГД-т хэрэгжих 6,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Бага сургууль цэцэрлэгийн цогцолбор (Баянгол дүүрэг, 22 дугаар хороо)", БЗД-т хэрэгжих 4,246.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "3 км авто замын ажил (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 20, 33 дугаар хороо) ТАХ төлөвлөлтийн шаардлага хангаагүй буюу ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3.3[22] дахь заалттай нийцээгүй байна.*

## ***Хуулийн 13 дугаар зүйлийн 13.4***

ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.4.1-т *"Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно"* гэж заасан.

---

*[21] 13.3.2.хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;*

*[22] 13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.*

Гэвч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх 16,570.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ нь хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1[23] дэх, 30,950.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ нь 13.4.3[24] дахь заалттай тус тус нийцээгүй байна. Үүнд:

- *12,570.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ногоон байгууламж бүхий орчны тохижилт (Улаанбаатар, Баянгол дүүрэг)”, 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ногоон гудамж, дэд бүтэц (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг)”, 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “"3x3" сагсан бөмбөгийн талбайн тохижилт, шинэчлэл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/” ТАХ,*
- *22,950.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дүүргийн хатуу хучилттай авто зам, замын шинэчлэл, гүүрэн байгууламж (Улаанбаатар, Баянгол дүүрэг) Багц-1”, 4,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Авто зам авто зогсоол /Улаанбаатар, Багануур дүүрэг 1, 3 дугаар хороо/”, 3,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Авто замын шинэчлэл (Улаанбаатар, Баянгол дүүрэг, 2, 3, 4, 17, 18, 19 дүгээр хороо)” ТАХ.*

### ***<u>Хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь заалт</u>***

ТХТХ-ийн 13 дугаар зүйлийн 13.5-т “*Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ*” гэж заасан. Гэвч нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлэх 9,408.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 ТАХ-г зураг төсөвгүй баталсан нь дээрх хуулийн заалттай нийцээгүй байна. /Хавсралт 5/. Тухайлбал:

***Нийслэлийн ОНХС /6,140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ/***

- *ЧД-т хэрэгжих 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ерөнхий боловсролын сургуулиудын ариун цэврийн өрөөг засварлах, шинэчлэх ажил“, БЗД-т хэрэгжих 513.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын ажил”, БГД-т хэрэгжих 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил-1”, СБД-т хэрэгжих 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлтийн ажил”, ХУД-т хэрэгжих 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил”, СХД-т хэрэгжих 220.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил” ТАХ.*

***Дүүргийн ОНХС /3,268.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ/***

- *ХУД-т хэрэгжих 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг”, БЗД-т хэрэгжих 365.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Тохижилтын ажил”, 385.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гэрэлтүүлгийн ажил”, НД-т хэрэгжих 274.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Автобусны буудал байгуулах”, БГД-т хэрэгжих 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн зориулалттай орон сууцны гадна фасад засварлах ажил” ТАХ.*

Аудитын явцад *“...Улс болон орон нутгийн төсөв, ТБОНӨХЭ-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г зохион байгуулахад баримтлах журам, тэдгээрийн төлөвлөгөөний жагсаалтад тусгахыг хориглосон зүйлс, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлжүүлэх ТАХ-ний төлөвлөлтийн шаардлага буюу ТХТХ-ийн 13 дугаар зүйлийг мөрдөж чадаж байна уу?”* асуулгад 13 байгууллага буюу 13.5 хувь нь “Хангалттай бус”, “Хангалтгүй” гэсэн хариултыг өгсөн байна.

---

*[23] 13.4.1.орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт;*
*[24] 13.4.3.орон нутгийн авто замын засвар хийх;*

***ДҮГНЭЛТ: ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИАР ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАХ, САНХҮҮЖҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОСОН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСАН БАЙНА.***

## 2. ЦАХИМ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬД ЗААСАН ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛЖ АЖИЛЛАСАН УУ?

Цахим ХАА-ны зохион байгуулалт болон ХАА-ны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлах зохицуулалтыг ТХТХ-ийн 14[25] дүгээр зүйлд заасан бөгөөд тус зохицуулалттай холбоотой 18,118.0 сая төгрөгийн 549 зөрчил илэрсэн. /Хавсралт 6/.

*Хүснэгт 12. ТХТХ-ийн 14 дүгээр зүйлийн зөрчлийн хураангуй мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Байгууллага | 2023 он | | 2024 он | |
|---|---|---|---|---|---|
| | | Зөрчлийн тоо | Дүн | Зөрчлийн тоо | Дүн |
| 1 | Нийслэлийн харьяа | 143 | 2,902.1 | 406 | 15,215.9 |

*Эх сурвалж: НТАГ-ын СНАХ-ийн 2024, 2025 онд гүйцэтгэсэн аудитын тайлан, аудитын баг.*

Хүснэгтээс харахад зөрчлийн нийт дүнгийн 16.0 хувийг 2023 он, 84.0 хувийг 2024 оны зөрчил эзэлж байна. Үүнийг заалт тус бүрээр авч үзвэл:

*Хүснэгт 13. Нийслэлийн харьяа байгууллагуудын ТХТХ-ийн 14 дүгээр зүйлийн зөрчлийн мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Хуулийн зүйл, заалт / Байгууллагын ангилал | 14.1 | | 14.4 | | 14.5 | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зөрчлийн тоо | Дүн | Зөрчлийн тоо | Дүн | Зөрчлийн тоо | Дүн |
| 1 | ТШЗ | 234 | 3,890.7 | 51 | 6,380.2 | - | - |
| 2 | ТБОНӨХЭ | 235 | 3,840.0 | 28 | 3,752.8 | 1 | 254.3 |
| **Нийт** | | **469** | **7,730.7** | **79** | **10,133.0** | **1** | **254.3** |

*Эх сурвалж: НТАГ-ын СНАХ-ийн 2024, 2025 онд гүйцэтгэсэн аудитын тайлан, аудитын баг.*

Тухайлбал:

- *2023 онд УСУГ ОНӨААТҮГ 514.0 сая төгрөгийн 36, ХУД-ийн ТҮТ 279.3 сая төгрөгийн 16, ОСНААУГ ОНӨААТҮГ 181.6 сая төгрөгийн 11 удаагийн худалдан авалт,*
- *2024 онд Зорчигч тээвэр 3 ОНӨААТҮГ 468.7 сая төгрөгийн 26, Нийслэлийн ИТХ 470.4 сая төгрөгийн 26, НОСК ХК 197.8 сая төгрөгийн 10 удаагийн худалдан авалтыг тус тус хийсэн болович тухайн онуудад худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалт болон худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд тухай бүр хүсэлтийг төрийн ХАА-ны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлээгүй нь ТХТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1[26], 14.2[27] дахь заалт,*
- *2023 онд СХД-ийн ЗДТГ 252.6 сая төгрөг, НХХААГ 78.7 сая төгрөг, ЧД-ийн ЗДТГ 70.6 сая төгрөг, Нийслэлийн ДХЭЗТБХГ 39.5 сая төгрөг, БНД-ийн ИТХ 36.9 сая төгрөг,*
- *2024 онд СХД-ийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ 1,310.7 сая төгрөг, СБД-ийн ЗДТГ 891.3 сая төгрөг, ХУД-ийн ЗДТГ 878.1 сая төгрөг, НБОГ 390.6 сая төгрөг, БГД-ийн ЗДТГ 291.0 сая төгрөг, БЗД-ийн ЗДТГ 143.9 сая төгрөг, ОСБГ 21.1 сая төгрөгийн бараа, үйлчилгээг*

[25] *14 дүгээр зүйл.Цахим худалдан авалт*
[26] *14.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.*
[27] *14.2.Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ.*

*цахим дэлгүүрээс бус бусад этгээдээс худалдан авсан нь ТХТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.4[28] дэх заалт,*
- *БСШТ 254.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй багц ТАХ-г 2023 онд босго үнээс доош болгож, үнийн санал авалгүйгээр шууд гэрээ байгуулсан нь ТХТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.5[29] дахь заалттай тус тус нийцээгүй байна.*

Дээрх зөрчлүүд нь ТБОНӨХЭ-д цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалтыг тухайн онд ХАА-ны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтмол хүргүүлээгүйгээс цахим дэлгүүрийн бараа, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэнтэй холбоотой байна.

Аудитын явцад *"Цахим худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, сонгон шалгаруулалтыг цахимаар зарлах болон бусад этгээдээс худалдан авахыг хориглох зүйлс буюу ТХТХ-ийн 14 дүгээр зүйлийн эрх зүйн зохицуулалт хангалттай байна уу?"* асуулгад 42 байгууллага буюу 43.7 хувь нь "Хангалттай бус", "Хангалтгүй", *"Төрийн хэмнэлтийн тухай хуулийг цаашид хэрэгжүүлэхэд таны санал, зөвлөмж"* асуулгад 26 саналаас 8 санал буюу 30.8 хувь нь "ТХТХ-ийн 14 дүгээр зүйлийн эрх зүйн зохицуулалтыг эргэн харах" хариултыг өгч, дараах шалтгааныг дурдсан байна. Үүнд:

- *Цахим дэлгүүрийн вэбсайт ойлгомжгүй, үйл явц нь шат дамжлага ихтэй, байгууллагын онцлогт нийцсэн хэрэгцээт зүйлсийн сонголт хязгаарлагдмал, худалдан авсан бараа, материал, тоног төхөөрөмжийн чанар муу, зах зээлийн үнээс өндөр, байгууллагын бичиг хэрэг, хангамжийн материал зэрэг бага үнэтэй бараа, материалыг цахим дэлгүүрт огт байршуулдаггүй, бусад эх сурвалжаас худалдан авахыг хориглох нь байгууллагын үйл ажиллагааг явуулахад хүндрэл тулгарч байна гэжээ.*

***ДҮГНЭЛТ: НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯА ЗАРИМ БАЙГУУЛЛАГУУД ЦАХИМ ДЭЛГҮҮРЭЭС ХУДАЛДАН АВАХ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТЫГ ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.***

[28] *14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.*
[29] *14.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана.*

## БҮЛЭГ В. ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БУСАД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ҮР ДҮНТЭЙ БАЙСАН УУ?

Нийслэлийн ТЕЗ нь 2023-2024 онд нийт 183,606.9 сая төгрөгийн хэмнэлт үүсгэсэн хэдий ч хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь үйл ажиллагаагаа сайжруулах, эрчимжүүлэх шаардлагатай байна.

## 1. ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРЭГ БҮХИЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД ХЯНАЛТАА БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮҮ?

ТХТХ-ийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага болон хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх, хяналт тавих, удирдах албан тушаалтны зохицуулалтыг ТХТХ-ийн 19[30] дүгээр зүйлд заасан.

Нийслэлийн хэмжээнд ТХТХ-ийн хэрэгжилтэд хяналт[31] тавих чиг үүрэг бүхий Нийслэлийн ЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг ДАА, нийслэлийн ЗД-ын захирамж, албан даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүрэг бүхий нийслэлийн ЗДТГ-ын ХШҮГ байх бөгөөд эдгээр байгууллагууд нь дараах арга хэмжээг авч ажиллажээ.

***<u>Нийслэлийн ЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг ДАА</u>***

Нийслэлийн ЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг ДАА нь 2023-2024 онд хяналт, шалгалтад хамрагдсан байгууллагуудад ТХТХ-ийг мөрдөж ажилласан эсэхэд хяналт хэрэгжүүлсэн боловч, тухайлсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус аудит хийгээгүй байна.

***<u>Нийслэлийн ЗДТГ-ын ХШҮГ</u>***

ТХТХ-ийг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн ЗД 2022-2024 онд 3 захирамж, 2 албан даалгавар гаргасан бөгөөд ХШҮГ холбогдох 27 байгууллагаас хэрэгжилтийг авч, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг 2025 оны 02 дугаар сард Нийслэлийн ЗДТГ-т танилцуулсан байна.

*Хүснэгт 14. ТХТХ-ийн хэрэгжилттэй холбоотой ХШҮ-ний мэдээлэл*

| № | Огноо | Шийдвэр | Шийдвэрийн дугаар | Товч утга | Хэрэгжилт тооцсон байдал |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2022 он | Захирамж | А/656 | Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай | 100 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” |
| 2 | 2022 он | | А/657 | | |
| 3 | 2022 он | | А/789 | | 90 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” |
| 4 | 2024 он | Албан даалгавар | 01 | ХАА-ны талаар авах зарим арга хэмжээний тухай | 89 хувь буюу “Хэрэгжих шатандаа” |
| 5 | 2024 он | | 03 | Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг баримтлан ажиллах тухай | Тайлагнасан боловч нэгтгэж дүгнээгүй |

---

[30] *19 дүгээр зүйл.Хяналт,*

[31] *Нийслэлийн ЗД-ын 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр баталсан “Дүрэм батлах тухай” захирамжийн хавсралтын 1.1 “Дотоод аудитын алба (цаашид “Алба” гэх) нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтууд, Нийслэлийн хөгжлийн урт хугацааны бодлого, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн нийгэм, эдийн засгийн зорилтууд болон хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн үндсэн үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн.”*

*Эх сурвалж: Нийслэлийн ЗДТГ*

Дээрх захирамж, албан даалгаврын биелэлттэй холбогдуулж цаашид анхаарах 6 саналыг хүргүүлжээ. Тухайлбал:

- *...Нийслэлийн нийт нутгийн захиргааны байгууллагууд үйл ажиллагаандаа санхүүгийн сахилга батыг мөрдөж, үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, ТАХ-г тэвчиж, төсвийн хэмнэлтэд нийцүүлэн ажиллах гэжээ.*

ТХТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2-т *“Төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан энэ хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлнэ”* гэж заасан бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна.

- *Нийслэлийн харьяа байгууллагуудын 41 хувь нь хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан, 59 хувь нь хуулийг бүрэн дагаж, мөрдөөгүй байна. /2023, 2024 оны дундаж хувь/*

*График 4. ТХТХ-ийн зөрчилтэй болон зөрчилгүй байгууллагын 2023-2024 оны мэдээлэл*




*Эх сурвалж: Аудитын баг*

Аудитаар 2023 онд 610,274.2 сая төгрөг, 2024 онд 1,522,022.3 сая төгрөг, нийт 2,132,296.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

*Хүснэгт 15. Нийслэлийн 2023-2024 оны зөрчлийн мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Огноо | Зөрчлийн тоо | Зөрчлийн дүн | Биелэлт |
|---|---|---|---|---|
| **1** | 2023 он | 596 | 610,274.2 | 252,250.0 |
| **2** | 2024 он | 1128 | 1,522,022.3 | Хугацаа болоогүй. |
| **Нийт** | | **1724** | **2,132,296.5** | **252,250.0** |

*Эх сурвалж: НТАГ-ын ГНАХ, СНАХ-ийн 2024, 2025 онд гүйцэтгэсэн аудитын тайлан, аудитын баг.*

Хүснэгтээс харахад нийслэлийн харьяа байгууллагуудын 2023 онд илэрсэн 610,274.2 сая төгрөгийн зөрчил 41.3 хувийн хэрэгжилттэй, 2024 онд илэрсэн зөрчлийн биелэлтийг тооцох хугацаа болоогүй байна.

Аудитын явцад хуулийн үйлчлэлд хамаарах нийслэлийн харьяа 96 байгууллагаас *“...энэ хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах чиг үүргээ хэрэгжүүлж чадаж байна уу?”* асуулгад 8 байгууллага буюу 8.3 хувь нь “Хангалттай бус”, “Хангалтгүй” хариултыг өгч, дараах шалтгааныг дурдсан байна. Үүнд:

- ТХТХ нь бусад хуулиудтай уялдаагүйгээс шалтгаалж бодит нөхцөл байдалд хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж байна.

***ДҮГНЭЛТ: ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХЭДИЙ Ч ҮР ДҮН ХАНГАЛТГҮЙ БАЙНА.***

## 2. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛСЭНЭЭР ХЭМНЭЛТТЭЙ, ҮР АШИГТАЙ БАЙСАН УУ?

ТХТХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад *“төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино”* гэж заасан.

Нийслэлийн 2023, 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд нийт зардлыг 6,871,719.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 5,278,182.5 сая төгрөгийг зарцуулсан гэж тусгажээ.

*Хүснэгт 16. Нийслэлийн 2023-2024 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | 2023 оны нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 2,357,713.3 | 1,915,903.3 | 81.3 | 441,810.0 | 18.7 |
| **2** | 2024 оны нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 4,514,006.6 | 3,362,279.2 | 74.5 | 1,151,727.4 | 25.5 |
| **Нийт** | | **6,871,719.9** | **5,278,182.5** | **77.9** | **1,593,537.4** | **22.1** |

*Эх сурвалж: НТАГ-ын СНАХ-ийн 2024, 2025 онд гүйцэтгэсэн аудитын тайлан.*

Аудитаар тайлант оны төлөвлөгөө болон зарцуулалтын зөрүү дүнг ТХТХ-тай холбогдуулж үүссэн хэмнэлт мөн эсэхийг тулган баталгаажуулахад 1,409,930.4 сая төгрөг буюу 88.4 хувь нь зарцуулагдаагүй үлдэгдэл, харин 183,606.9 сая төгрөг буюу 11.6 хувь нь хэмнэлт байна. Тухайлбал:

- *2023 онд Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахимжуулснаар бичиг хэргийн зардлыг 133.6 сая төгрөг, шуудан, холбооны зардлыг 228.1 сая төгрөг,*
- *Газрын хянан баталгааны зардлын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосноор 900.0 сая төгрөг,*
- *“Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээний зардал” ТАХ-г харъяа ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлснээр 1,200.0 сая төгрөг,*
- *Хууль тогтоомжид зааснаас бусад тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохгүй байх хязгаарлалтыг мөрдөж ажилласнаар 1,430.5 сая төгрөг,*
- *Нийслэлийн ногоон бүс, Туул, Сэлбэ, Дунд голын ай сав, нийтийн эзэмшлийн гудамж талбайн хог хаягдлыг дарж булах ажилд иргэдийн бүлгийн ажилчдыг татан оролцуулснаар 1,926.8 сая төгрөг,*
- *Насжилт өндөр шугам хоолойг шинэчлэн засварлаж, усны тоолуурыг тухай бүр баталгаажуулалт хийлгэснээр 4,362.7 сая төгрөг,*
- *Нийслэлийн засаг захиргааны байр болон дэд төвүүд дэх гэрлүүдийг эрчим хүчний зарцуулалт багатай гэрлээр сольж, шинэчилсэн, мөн тэдгээрийн цахилгаан, эрчим хүчний хэрэглээний ашиглалтыг сайжруулснаар 8,381.1 сая төгрөг,*
- *Зорчигчдийн тоо, сургуулийн автобусны санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосноор төрийн өмчит байгууллагад олгох татаасыг 17,958.9 сая төгрөг,*
- *2024 онд нийслэлийн нутгийн захиргааны төв цогцолбор барилга 2024 оны эхний улиралд бүрэн ашиглалтанд ороогүй, тус барилгын А, Б блокт цэвэр бохир ус, эрчим хүчний баталгаат тоолуур суурьлуулсан, мөн СБД-ийн 2 болон 17 дугаар хороо шинэ байртай болж түрээсийн зардал гаргаагүй зэрэг шалтгаанаар байр ашиглалтын зардлаас 1,206.9 сая төгрөг,*
- *Дүүргүүдийн хог тээврийн зардлын санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн улирал бүр тулган баталгаажуулж олгосноор 2,100.0 сая төгрөг,*
- *СБД-ийн ажлын албаны 8 автомашиныг нийслэлийн ТЗАБ-д шилжүүлсэн, НӨХГ-аас 5 автомашиныг дуудлага худалдаагаар борлуулсан, мөн шатахууны зардлыг 10 хувиас*

*багагүй хэмнэлт үүсгэх зорилт тавин ажилласнаар тээвэр, шатахуун зардлаас 10,742.4 сая төгрөгийн хэмнэлтийг тус тус бий болгожээ.*

*• Харин 2023 онд Нийслэл, дүүргийн халамжийн сангаас онцгой тохиолдол болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг гүйцэтгэлд үндэслэн олгосноос үүссэн зөрүү 1,871.8 сая төгрөг,*
*• Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар татан буугдсантай холбоотойгоор төрөөс иргэдэд олгох нэг удаагийн тэтгэмж зардалд олгоогүй 5,600.0 сая төгрөг,*
*• Зураг төсөв нь батлагдаагүй, тухайн ондоо хэрэгжээгүй, хойшлогдсоноос бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардалд олгоогүй 12,449.8 сая төгрөг,*
*• Нийслэлийн харьяа байгууллагуудын хэмжээнд орон тоо дутуу ажилласнаас цалин, шимтгэлийн зардалд олгоогүй 14,121.5 сая төгрөг,*
*• ТАХ-ний ХАА удааширч, гүйцэтгэгч оройтож шалгарсантай холбогдуулж нийслэлийн замын сангийн хөрөнгөөс татагдсан 306,757.4 сая төгрөг,*
*• 2024 онд гэрэл, цахилгаан, түлш халаалтын зардлыг 20-40 хувь өсөхөөр төлөвлөж баталсан ч тухайн онд нэмэгдээгүйгээс шалтгаалж төлөвлөлт болон гүйцэтгэлийн зөрүү 19,265.3 сая төгрөг,*
*• Нийслэлийн харьяа байгууллагуудын хэмжээнд орон тоо дутуу ажилласнаас цалин, шимтгэлийн зардалд олгоогүй 27,812.5 сая төгрөг нь тус тус зарцуулаагүй үлдэгдэл байна.*

***ДҮГНЭЛТ: НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ 2023-2024 ОНД НИЙТ 183,606.9 САЯ ТӨГРӨГИЙН ХЭМНЭЛТ ҮҮСГЭСЭН БАЙНА.***

## 3. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН УУ?

ТХТХ-ийн 3[32] дугаар зүйлд заасан хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр нь улс, орон нутгийн төсөв болон өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[33] дахь заалт, ШДТХ-ийн 6[34] дугаар зүйлд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд, нийтэд ил тод мэдээллэхээр заасан.

Аудитаар 28,431.6 сая төгрөгийн дүнтэй 97 мэдээг тогтоосон хугацаанд мэдээлээгүй, 703,957.5 сая төгрөгийн дүнтэй 43 мэдээг огт мэдээлээгүй, нийт 732,389.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. /Хавсралт 7/.

*Хүснэгт 17. ТХТХ-ийн 20.5 дахь заалтын зөрчлийн мэдээлэл*

*/сая.төг/*

| № | Байгууллага | 2023 он | | | | 2024 он | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тогтоосон хугацаанд мэдээллээгүй зөрчлийн | | Огт мэдээллээгүй зөрчлийн | | Тогтоосон хугацаанд мэдээллээгүй зөрчлийн | | Огт мэдээллээгүй зөрчлийн | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Нийслэлийн харьяа | 50 | 9,951.1 | 20 | 326,642.3 | 47 | 18,480.5 | 23 | 377,315.2 |

*Эх сурвалж: Нийслэлийн 2024, 2025 оны санхүүгийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан*

Хүснэгтээс харахад нийслэлийн харьяа байгууллагаас 2023 онд 68.4 хувь, 2024 онд 68.8 хувь нь мэдээллийг тогтоосон хугацаанд, нийтэд ил тод мэдээлж ажилласан байна.

***ДҮГНЭЛТ: ДУНДЖААР НИЙСЛЭЛИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН 68 ХУВЬ НЬ ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙГ МӨРДӨЖ АЖИЛЛАСАН БАЙНА.***

[32] *3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ*
[33] *20.5.Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна.*
[34] *6 дугаар зүйл.Шилэн дансны мэдээлэл;*

# САНАЛ, АСУУЛГЫН ДҮН:

Аудитын явцад хуулийн үйлчлэлд хамаарах нийслэлийн харьяа 96 байгууллагаас 8 чиглэлээр санал, асуулга авч, дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна.

*Хүснэгт 18. Санал асуулга, хариултын нэгтгэл*

<table>
<tr><th rowspan="2">№</th><th rowspan="2">Асуулгын агуулга</th><th colspan="2">Хангалттай хариулт өгсөн</th><th colspan="2">Хангалтгүй хариулт өгсөн</th></tr>
<tr><th>Байгууллагын тоо</th><th>Эзлэх хувь</th><th>Байгууллагын тоо</th><th>Эзлэх хувь</th></tr>
<tr><td>1</td><td>ТХТХ-ийн 5-12 дугаар зүйл буюу Төр, түүний бүх шатны байгууллага, ТБОНӨХЭ-ийн тэргүүн дэд, дэд, орлогч даргын орон тоо, тээврийн хэрэгслийн ашиглалт, захиргааны зориулалтаар барилга шинээр барих, албан тасалгаа, албан хаагчдын дүрэмт хувцас, албан томилолт, цалин хөлс, түүний нэмэгдэл, нэг удаагийн мөнгөн тэтгэмж болон бусад хангамжийн үрэлгэн байдлыг хязгаарлах зохицуулалт хангалттай байна уу?</td><td>77</td><td>80.2</td><td>19</td><td>19.8</td></tr>
<tr><td colspan="6">Иргүүлсэн саналын нэгтгэл:<br>Одоогийн мөрдөгдөж буй хуулийн зүйл, заалт нь бодит байдалд байгууллагын үйл ажиллагааны чиглэл, онцлогтой нийцээгүй, зөрчилдөх тохиолдол гарч байгаа нь зохицуулалтын уян хатан бус байдал, нийтлэг байдлаар томъёолсон заалтуудтай холбоотой. Иймд байгууллагын үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн, илүү тодорхой, уян хатан зохицуулалт бүхий эрх зүйн орчинг бүрдүүлэх нь зүйтэй байна.</td></tr>
<tr><td>2</td><td>Танай байгууллага Улс болон орон нутгийн төсөв, ТБОНӨХЭ-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г зохион байгуулахад баримтлах журам, тэдгээрийн төлөвлөгөөний жагсаалтад тусгахыг хориглосон зүйлс, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлжүүлэх ТАХ-ний төлөвлөлтийн шаардлага буюу ТХТХ-ийн 13 дугаар зүйлийг мөрдөж чадаж байна уу?</td><td>83</td><td>86.5</td><td>13</td><td>13.5</td></tr>
<tr><td>3</td><td>Цахим худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, сонгон шалгаруулалтыг цахимаар зарлах болон бусад этгээдээс худалдан авахыг хориглох зүйлс буюу ТХТХ-ийн 14 дүгээр зүйлийн эрх зүйн зохицуулалт хангалттай байна уу?</td><td>54</td><td>56.3</td><td>42</td><td>43.7</td></tr>
<tr><td colspan="6">Иргүүлсэн саналын нэгтгэл:<br>Цахим дэлгүүрийн вэбсайт ойлгомжгүй, үйл явц нь шат дамжлага ихтэй, байгууллагын онцлогт нийцсэн хэрэгцээт зүйлсийн сонголт хязгаарлагдмал, худалдан авсан бараа, материал, тоног төхөөрөмжийн чанар муу, зах зээлийн үнээс өндөр, байгууллагын бичиг хэрэг, хангамжийн материал зэрэг бага үнэтэй бараа, материалыг цахим дэлгүүрт огт байршуулдаггүй, бусад эх сурвалжаас худалдан авахыг хориглох нь байгууллагын үйл ажиллагааг явуулахад хүндрэл тулгарч байна гэжээ.</td></tr>
<tr><td>4</td><td>Танай байгууллага ТХТХ-ийн 15 дугаар зүйл буюу Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглох зүйлс болон авч хэрэгжүүлэх хэмнэлтийн бусад арга хэмжээг мөрдөж чадаж байна уу?</td><td>88</td><td>91.7</td><td>8</td><td>8.3</td></tr>
<tr><td>5</td><td>Та болон танай байгууллага энэ хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах чиг үүргээ хэрэгжүүлж чадаж байна уу?</td><td>88</td><td>91.7</td><td>8</td><td>8.3</td></tr>
<tr><td colspan="6">Иргүүлсэн саналын нэгтгэл:<br>ТХТХ нь бусад хуулиудтай уялдаагүйгээс шалтгаалж бодит нөхцөл байдалд хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж байна.</td></tr>
<tr><td>6</td><td>Танай байгууллага Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлсэнээр хэмнэлттэй, үр дүнтэй байна уу?</td><td>82</td><td>85.4</td><td>14</td><td>14.6</td></tr>
<tr><td colspan="6">Иргүүлсэн саналын нэгтгэл:<br>ТХТХ-г хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч байгууллагын үйл ажиллагаа төдийлөн үр дүнтэй болж чаддаггүй. Тайлан, мэдээ нэмэгдсэнээс бусад ямарч илэрхий үр дүн гарахгүй байна.</td></tr>
<tr><td>7</td><td>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн талаар таны үнэлэмж?</td><td>60</td><td>62.5</td><td>36</td><td>37.5</td></tr>
<tr><td colspan="6">Иргүүлсэн саналын нэгтгэл:<br>Шинээр бий болгох тогтолцоо, бодлогын зорилт, чиг үүрэг, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байх тул зохицуулалт хийж, уян хатан болгох. Цаг, үе нөхцөл байдлын онцлог, шаардлагад нийцсэн тодорхой</td></tr>
</table>

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| хүрээний зохицуулалт хэлбэрээр байх нь зөв гэж үздэг. Бүхэлд авч үзвэл бодит нөхцөл байдалд нийцэхгүй байна. | | | | | |
| 8 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг цаашид хэрэгжүүлэхэд таны санал, зөвлөмж? | 70 саналгүй | 72.9 | 26 саналтай | 27.1 |
| Дараах саналуудыг ирүүлсэн байна. Үүнд:<br>1 санал буюу 3.8% нь ТХТХ-ийн 5, 6 дугаар зүйл эрх зүйн зохицуулалтыг эргэн харах;<br>2 санал буюу 7.7% нь ТХТХ-ийн 9 дүгээр зүйл, 15 дугаар зүйл эрх зүйн зохицуулалтыг эргэн харах;<br>2 санал буюу 7.7% нь зарим ажил, бараа, үйлчилгээг ТХТХ-иас хасах, өөрчлөх;<br>2 санал буюу 7.7% нь хуулийн үйлчлэлийг зогсоох;<br>3 санал буюу 11.5% нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаад анхаарах;<br>4 санал буюу 15.4% нь байгууллагын онцлогийг харгалзаж, хуулийн зохицуулалтыг уян хатан болгох;<br>4 санал буюу 15.4% нь ТХТХ нь бусад хууль, тогтоомжтой уялдаж байгаа эсэхэд анхаарах,<br>8 санал 30.8% нь ТХТХ-ийн 14 дүгээр зүйлийн эрх зүйн зохицуулалтыг эргэн харах. | | | | | |

*Эх сурвалж: НТАГ-ын санал асуулгын нэгтгэл*

# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ

МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2026.05.12 № 01/3041

танай ______ -ны № ______ -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
М.ЭРДЭНЭЖАРГАЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүн" сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах нийслэлийн харьяа 225 байгууллагаас 67 байгууллага буюу 30 хувийг түүвэрлэж аудит хийсэн боловч Монгол Улсын шадар сайд, Сангийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайд, Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайд, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын сайд, Эрчим хүчний сайдын төсвийн ерөнхийлөн захирагчид тус тус хамаарах давхардсан тоогоор 608 байгууллагын зөрчлийг нэгтгэн ирүүлсэн байна.

Тайлбар 1-г үзэх

Мөн нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, шилэн дансны болон бусад хууль тогтоомжийн буюу цахим худалдан авалтын хэрэгжилтэд 2024 онд хийсэн нийцлийн аудитаар тус тус илэрсэн зөрчлүүдийг давхардуулан ирүүлсэн байна.

Тайлбар 2-г үзэх

Иймд Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээд тул зөвхөн нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах байгууллагууд болон "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт үр дүн" сэдэвт нийцлийн аудитын хүрээнд илэрсэн зөрчлийг дангаар ирүүлэх нь зүйтэй байна.

Тайлбар 3-г үзэх

Нийслэлийн харьяа байгууллагуудаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчлийн талаар хүргүүлсэн тайлбар, тодруулгыг харгалзан үг хуулийн хэрэгжих боломжгүй зарим зүйл, заалтыг өөрчлүүлэх саналыг эрх бүхий байгууллагад уламжилж бидний ажилд дэмжлэг үзүүлж өгнө үү.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

1725061336

## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

